



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар A/30

Өмнөдэлгэр сум

Сургуулийн дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 39 дүгээр зүйлийн 39.8 дах хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/239 дугаар тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургалтын байгууллагад болзошгүй эрсдэл, суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн орчин бүрдүүлэх зорилгоор сургуулийн дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч Д.Шижиртуяа	(Нийгмийн ажилтан)
С.Удвалцэцэг	(Сэтгэлзүйч)
М.Гангаанай	(Химийн багш)
М.Лхагвадулам	(Англи хэлний багш)
М.Рэгзэнсүрэн	(Бага ангийн багш)
Б.Ганхуяг	(Биеийн тамирын багш)
О.Нармандах	(Сантехникч)

2. Байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон холбогдох хууль журамтай уялдуулан боловсруулж байгууллагын дотоод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан,

нөхцөлийг судлан арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллан биелэлтийг улирал тутам тайлагнахыг зөвлөлийн дарга (Д.Шижиртуяа)-д үүрэг болгосугай.

3.Суралцагчид болон ажилтнуудаа гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

4.Барилга байгууламжийн гадна, дотор орчны аюулгүй байдлыг хангаж зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник хэрэгслийг зориулалтын дагуу ашиглахад хяналт тавин "Хичээлийн болон дотуур байранд хяналтын камер ашиглах журам"-ыг боловсруулан мөрдүүлж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

5.Сургалтын байгууллагад болзошгүй эрсдэл, суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн орчин бүрдүүлэх, сургуулийн дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдож журам, зөвлөмжийн дагуу заагдсан төсөв багтаан зарцуулахыг нягтлан бодогч (М.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан захирлын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

